


# Бяцхан шар шувуухай

Лене Маяр-Скуманц / Салваторе Шиашиа

ОРЧУУЛСАН: МӨНХ МЭНДЖАРГАЛ



Эрт урьдын цагт амьтан хүн хоёр нэгэн ижил хэл яриагаар ойлголцдог байсан ба тэр үед сэтгэл татам үзэсгэлэнт сайхан уулын ард нэгэн бяцхан шар шувуухай эцэг эхийн хамт амьдардаг байжээ. Тэр бяцхан шар шувуухай зургаан эгч дүүсийн хамгийн бага нь байсан ба мөн тэр уулын хөгшин модны хонгилийг хамгийн сүүлд орхин нисэж байсан билээ. Түүний эцэг эх нь шар шувуухайд яаж хулгана барьж, яаж нарны элчийг өөртөө татдаг зэргийг заан сургасан ба энэ бүгдийг сурахад ухаан хэрэгтэй гэж аав ээж нь хэлжээ. Гэтэл бяцхан шар шувуухай энэ бүгдийг сурахад би дэндүү жижиг дэндүү залуу бишүү гэж асуулаа? Түүнийг ингэж асуусны дараа эцэг эх нь мод тонших зуураа хүлцэнгүй харцаар харж Чи нас бие гүйцэж том болсон одоо аян замдаа гар даа. Олсон амьтнаа аль болох зовоохгүйгээр хурдан агнах хэрэгтэй. Хэдий чинээ хурдан ална амт нь төдий чинээ сайхан байдаг юм. Чи энэ бүгдийг мэднэ шүү дээ. Өдөр шөнө аль нь ч байсан баярлаж бай, нисэхийг нисэж байж л сурна өөр чамд юу гэж хэлэх билээ дээ. Ингээд тэр бяцхан шувуу эцэг эхийнхээ сургамжийг хүлээн авч төрж өссөн уулын модоо харан харсаар нисэн оджээ. Нэгэн үзэсгэлэнт сайхан уулын ард сүрэг амьтад байжээ. Бяцхан шар шувуу хэсэг газар ниссэнийхээ дараа хадтай ойн хонгил олж харлаа.



Гэтэл түүний сууж байсан хадны дор нарны элчинд халсан хадан чулуун дээр нэгэн зэрлэг муур хэвтэж байв. Тэр зэрлэг муур сахлаг цагирган өтгөн сүүлээ зөөлөн зөөлөн шавхуурдангаа толгойгоо өндийлгөн хоёр нүдээрээ шар шувууруу чиглүүлэн харж: Шар шувуухай чи яг зөв цагт иржээ. Яагаад зэрлэг муурнууд бүгдийг дийлж чаддаг юм бэ? Чи үүнийг надад хариулж өгчөөч. Яаж яаж? Бяцхан шар шувуухай машид гайхав. Өчигдөр орой би урьд өмнө нь хэзээ ч гүйж байгаагүй тийм хол гүйсэн горхи хүртэл тэнд би мод чулуугаар барьсан хүний байр олж харсан ба эргэн тойронд нь тослог сайхан үнэр үнэртэж байлаа. Би хэдийгээр цатгалан байсан ч холоос бага зэрэг ширтэн суусан. Гэтэл байрны өмнө нэгэн хүн муурыг өвөр дээрээ суулгаад эрхлүүлж байхыг харлаа. Муур түүнийг хазаж самардахгүй харин түүнд эрхэлж байлаа. А яа яа яаж үүнийг эрхлүүлж байна гэж бодохоор миний хамаг бие хүйт оргих шиг боллоо. Бяцхан шар шувуухай толгойгоо бөхийлгөн: „Би үүнийг яагаад мэдэх ёстой юм бэ?“ Зэрлэг муур ууртайгаар сүүлээ шавхуурдан нүдээ шар ногооноор эргэлдүүлэв.




Чи үүнийг надаас асууж байгаа юмуу?“, гэж турхиран,, Чи чинь шар шувуу биз дээ! Шар шувуунууд дэлхий дээрх бүх асуултын хариултыг мэддэг шүү дээ. Би үүнийг мэдэхгүй гэж тоомсоргүй хариулав. Гэтэл зэрлэг муур : Чи юуны төлөө шар шувуу болж төрөө вэ? Өөрийгөө хараад ичихгүй байна уу? Чи цаашдаа ямарч амжилт олохгүй гэж архирав. Төдөлгүй сандарч балмагдсан шар шувуухай нисэн одовч жаргаж буй нарны гэрэлд гэрэлтсэн нэгэн өндөр мод олон түүний хамгийн доод талын мөчир дээр бодлогоширон суулаа. Гэтэл газраас тогос шувуу том далавчаа дэвсээр нисэж түүний хажууд ирж суухад бяцхан шувууны сууж байсан модны мөчир нахилзаж байлаа. Тогос бяцхан шар шувуунд хандаж арай гэж давлаа. Орой болгон унтахын өмнө ямар ядаргаатай гээч би яахаараа хурдан гүйдэг шигээ сайн нисэж чаддаггүй юм бэ? Хөөе хэн энд сууж байнаа? Бяцхан минь сонс! Энэ миний мод гэв. Шар шувуухай уучлаарай гэж нахилзав. Тогос гоо үзэсгэлэнт өдөө дэлгэн өө чи чинь шар шувуу байна шүү дээ хэмээн өдөө хумин газарлуу чиглүүлэв.

Тогос намайг бодолд оруулсан нэг асуулт байна. Бүгдийг хийж бүтээж чаддаг том тогос яахаараа ийм бага унтах талбайтай байх ёстой юм бэ? гэхэд бяцхан шар шувуу аахилан яагаад гэжээ? Тогос миний энэ урт далавчыг харж байгаа биз дээ. Намайг амгалан сайхан унтахад энэ саад болж байна. Үүнд маш том чулуун мөчиртэй мод хэрэгтэй ба түүн дээрээ би далавчаа зөв байрлуулж тайван унгаж чадна. Ийм мод энд маш ховор гэлээ. Шар шувуу чиний энэ мод чинь энэ биш үү гэж зөөлөн хэлэхэд тогос надад гурав дөрвөн мод хэрэгтэй байна гэж хашгиралаа. Яагаад энд мод ховор байдаг юм бэ? надад хариулаач гэхэд шар шувуу би үүнийг мэдэхгүй гэж хариулсанд тогос ууртайгаар: Толгойгоо бөхийлгөн өдөө шар шувууны цээжинд хүргэн чи үүнийг яагаад мэдэхгүй гэж? Шар шувуу бүгдийг мэддэг шүү дээ гэлээ. Бяцхан шар шувуу би үнэхээр мэдэхгүй гэхэд тэнэг

минь , чи тэгвэл жинхэнэ шар шувуу биш гэж уурлав.Чи өөрөөсөө ичээч хол явж үз гэхэд айж цочсон шар шувуу нисэн одлоо.

Төдөлгүй бяцхан шар шувуухай том хадны хонгил олж тэнд амсхийн суунгаа ахин бодлоо. Би яагаад өөрөөсөө ичих ёстой юм бэ? Би яахаараа дэлхий дээр бүхнийг мэдэх ёстой юм бэ? гэж өөртөө зөөлөн хэлэв. Зэрлэг муур яахаараа том зэрлэг муурнууд бүгдийг хийж бүтээсэн гээд тогос яахаараа том тогоснууд бүгдийг хийж бүтээсэн гэж байгаа юм чинь тэгвэл том шар шувуу бас бүгдийг хийж бүтээсэн гэж хэлж болох юмуу? гэж хэллээ. Орой болж нар үзэсгэлэнт сайхан уулын цаагуур орж тэнгэрт од гялтганаж, сар гарч ирэхэд сарны гэрэлд хадны хонгил гэрэлтэн шар шувуу сарны мөнгөн гэрэлд баясан сууж байлаа. Гэтэл шар шувууны ард чив чив гэх чимээ гарав. Ямар сайхан амгалан шөнө вэ! Бүгдийг сарьсан багваахай хийж бүтээсэнд баярлах хэрэгтэй гэжээ. Шар шувуу эргэн хартал хаднаас нэгэн сарьсан багваахай хөлөөрөө зүүгдсэн байхыг олж харав.Тэр сарьсан багваахай хамрын нүхнээсээ гарч байгаа тослог шингэнийг хэлээрээ долоон авч биеийн бүх арьсандаа тараан түрхэж байхыг хараад,,Пээх, ямар өмхий юм гэж дуу алдав.



Сарьсан багваахай ч тиймээ энэ өмхий байгаа биз гэж бататгав.Тийм болохоор би чамд хоол байхгүй эрхэм анд минь, чи чинь шар шувуу биз дээ, эсвэл? Шар шувуу хариуд нь тиймээ би жижигхэн зөвхөн шар шувуу байна эсвэл бүр шар шувуу биш ч байж магадгүй гэжээ. Гэтэл сарьсан багваахай шар шувуу л бол шар шувуу шүү дээ. Шар шувуунууд дэлхий дээрх бүх асуултын хариултыг мэддэг шүү дээ.,,Надад чамаас асуух нэг асуулт байна эрхэм анд минь.“ Сарьсан багваахай хаднаас зүүгдэн явсаар түүний өмнө ирээд: Намайг хар би яаж ийм уран аргаар бүтээгдсэнийг би хоол тэжээлээ харанхуй шөнөөр олдог, би чанга орилоход миний хоол тэжээл бүх амьтны дуу миний чихэнд цуурайтан сонсогдоход би тэднийг барьж авдаг. Гэхдээ намайг зовоосон нэг л асуулт байна. Тэр бол би жилд нэг удаа нэг л хүүхэд гаргадаг. Эрвээхэй, удган хорхойнууд гэхэд маш олон өндөг гаргадаг, зараа гэхэд олон жижиг зараа гаргадаг, үнэг

гэхэд доод тал нь гурван зулзага гаргадаг. Том сарьсан багваахай бүгдийг хийж чадсан байж бидэнд яахаараа ганц хүүхэд гаргах боломж өгсөн юм? гэлээ. Шар шувуу би үүнийг бас мэдэхгүй гэж хариулав. Сарьсан багваахай урагш хойш нахилзан гайхалтайгаар чи үүнийг бас мэдэхгүй гэжүү? Би яаж үүнд чинь итгэх юм бэ? гэв. Би үнэхээр мэдэхгүй гэж шар шувуу чангаар орилов.



Чи үүнийг мэдэхгүй бол хэн үүнийг мэдэх юм бэ? гэж сарьсан багваахай гунигтайгаар асуулаа. Сарьсан багваахай чи үүнийг чин сэтгэлээсээ хариулъя гэж чармайхгүй байгаа байх тийм үү гэж хэллээ. Хэрвээ чи хэзээ нэгэн цагт миний асуултын хариуг олвол надад хэлээрэй гэхэд шар шувуу хүлцэнгүйгээр толгой дохилоо. Сарьсан багваахай сайн байна гээд агаарт нисэхэд түүний хурдан чанга хашгирах нь агаарт замхарахад түүний араас бусад сарьсан багваахайнууд нисэн одлоо. Бяцхан шар шувуухай тэдний араас харахад сарны гэрэлд нахилзан гуйвж байлаа.



Зовлонд баригдсан шар шувуу өөрийнхөө өлсгөлөнд баригдсаныг мэдээд анд гарлаа. Тэр цахилгаан шиг хурдан хөдлөн хулганыг бариж идээд цатгалан болсныхоо дараа хулганад хандан: „Хулганаа чи надад хариулж өгөөч:

Ямар ухаантай амьтан чамайг бас намайг ер нь бүгдийг хийж бүтээсэн юм бэ? гэхэд хэсэг хугацааны дараа хулгана хариулсан нь: „Том хулгана л байхгүй, өөр хэн байхав? Чи энэ бүгдийг мэднэ шүү дээ, бүхнийг мэдэгч минь! Чи бүгдийг мэддэг байж яагаад асуугаад байгаа юм хорон санаатаа, намайг нүхнээс минь гаргах гээ юу? Хэрэв бидний хэн нэг нь дутвал чи буруутай. Хэрэв би энэ бүгдийг мэдэж байгаа бол яагаад шар шувуу та нарыг үр тариа ногоогоор хоололдгүйг мэдэх байсан” гэснээ үгүй ээ үр тариа чинь бидний хоол шүү дээ гэж зөөлөн хэлээд таг болов. Шар шувуу цааш нисэн одож амрахаар нэгэн өндөр уулын оргил дээр суун, ”үхү үхү би бүхнийг мэдэгч биш харин би бол бүгдийг үл мэдэгч” энийг би өөрөө мэдэж байна гэж хашгирав. Түүний доогуур нэгэн бүдүүн цагираган сүүл сүүдэрлэн өнгөрөв. „Гэнэт нану гэх нэгэн чимээ гарлаа. Бяцхан шар шувуухай эргэн тойрон харан би сурах болноо гээд унтлаа.



Үүр цайж навчис гялалзахад шар шувуу нарны гялалзсан туяанд баясан суулаа. Тэрээр би өнөөдөр юу олж юу шинээр сурах вэ? гэж өөрөөсөө асуунгаа үг дуугүй далавчаа дэлгэн үзэсгэлэнт сайхан уулын зүг нисэн одлоо. Ингээд нисэх зуураа урьд өмнө нь байсан горхи ,хүмүүсийн байр, зэрлэг мууртай ярьсан яриа бүгдийг эргэн санажээ. Эргэн тойрон нам жим амар амгалан хэдэн тахиа газар тоншин өт идэж байлаа. Гэнэт горхины ойролцоо ямар нэгэн хүний авиа сонсогджээ. Тэр тийшээ нисэн очтол нэгэн эмэгтэй горхиноос ус савалж байгаа харагдав.

Шар шувуу бургасан дээр дөхөн суунгаа,” чи ямар гоё хоолойтой юм бэ? минийхээс ч сайхан хоолойтой “юмаа гэхэд эмэгтэй шар шувууг хараад

инээд алдав. Тэгээд хэлсэн нь: Бүх амьд амьтан яг адил байсан бол дэлхий уйтгартай байх байсан биз дээ. Жишээ нь: чи надаас сайн харж, сайн сонсож чаддаг, би чам шиг нисэж чадахгүй шүү дээ гэлээ. Тэгвэл чи яагаад дуулж байгаа юм бэ? Гэж шар шувуу асуухад чи өөрийхөө хүнсний талбайгаа бусад хөөндэй шиг хамгаалахыг хүснэ биз дээ? Тэрэн шиг л би дуулвал миний ажил амархан хурдан бүтдэг юм. Заримдаа би бүгдийг хийж бүтээсэн том ээжид дуулдаг юм гэлээ. Тэр хаана амьдардаг юм гэж шар шувуу асуулаа. Хаа сайгүй хүмүүс түүнийг олж харж чадахгүй нар, сар, тэнгэрийн од энэ бүгд чинь зөвхөн түүний хувцсан дээрх гоёл байгаа юм. Тэгвэл энэ горхины загаснууд бүгдийг том загаснууд хийж бүтээсэн гэж мэдэж байгаа юу? Ингэж хэлэхэд бүхнийг хийж бүтээсэн том ээж уурлахгүй юу? гэхэд эмэгтэй тэр уурлахгүй тэр бүхнийг хайрлах сайхан сэтгэлтэй гэж хэллээ. Шар шувуу толгойгоо нааш цааш хөдөлгөн эргэн бодонгоо.”Хэрэв чи том ээжийг хүндэтгэн дуулвал тэр баярлах болов уу?” гэхэд эмэгтэй би түүнийг баярлуулж байгаа гэж бодож байнаа би бас түүнээс их зүйлийг гуйдаг.

Миний амьдарч байгаа байрны дээвэр олон жил болж, миний тахианууд их өндөг гаргаж, биднийг эрүүл энх байлгаарай гээд л... Чи маргаашийн болох юманд санаагаа их зовоодог юмуу гэхэд эмэгтэй: үүнийг бүгд л боддог шүү дээ гэжээ. “Өнөөдөр бороо орох үгүйг чи мэдэх үү? Би угаасан юмаа норгохгүй авмаар байна.” Бороо орохгүй юм шиг байна гэж шар шувуу хэлээд нисэн одлоо. Нар бүтэн өдөржингөө шарж шар шувуу нарны элчинд биеэ ээнгээ бүгдийг эргэн бодлоо. Ингээд орой болж шар шувуу үзэсгэлэнт уулын зүг нислээ. Төдөлгүй шөнө болж модны завсраар ямар нэгэн туяа яг алтан од шиг гялалзаж байлаа. Тэр гялалзах туяан дээгүүр нисэн өчүүхэн жижиг модон байшин байхыг олж хараад өөрийг нь элбэдэж байгаа юм шиг бодол төрүүлэв. Тэр дөхөн очиход хэн нэгэн бүдүүн дуугаар манай цонхны тавцан дээр нэг шар шувуу сууж байна гээд “Тавтай морилно уу?” гэжээ. Шар шувуу гэрлийн гялалзах туяанд нэгэн хөгшин эрэгтэй хүн сууж байхыг харлаа.



Бяцхан шар шувуу тэр эрэгтэйгээс чи энд юу хийж байгаа юм бэ? гэж асуулаа. Би уншиж байна гээд шөнийн эрвээхэйг зөөлөн үргээнгээ өдөр надад маш богино байсан учир би дэнгийн гэрэлд уншиж байгаа юм. Энэ бол бүхнийг хийж бүтээсэн том аавын тухай ном гэлээ. Тэгээд тэр том аав чинь хаана амьдардаг юм бэ? гэж шар шувуу асуулаа. Хаа сайгүй гэхдээ түүнийг би дэлхий дээр харж чадахгүй ч гэсэн тэр хүн бүхний зүрхэнд хоногшсон байдаг юм гэж эрэгтэй хариулав. Чи том ааваас маргаашийн төлөө гуйдаг уу? гэж шар шувуу асуухад эрэгтэй тэгэлгүй яахав. Гэвч би өнгөрсөн зүйлийн тухай илүү ихийг гуйдаг гэж хариулжээ. Тэгвэл том шөнийн эрвээхэй бүгдийг хийж бүтээсэн гэж шөнийн эрвээхэйнүүд мэдэх үү? гэж шар шувуу шулганахад эрэгтэй инээмсэглэн “би чамд бүхнийг хийж бүтээсэн том аавын тухай яаж ойлгуулах вэ? гэжээ.

Тэрээр горхины эмэгтэй чамд бүгдийг хэлж чадна гээд духаа үрчийлгэв.





Тэрэнд би том аавын тухай их зүйлийг ярьж өгсөн. Би бодохдоо энэ бүгдийг хэзээ нэгэн цагт мэдэх болно гэж бодож байна гэв. Хэрэв тэр эмэгтэй том ааваа гэж дуудвал тэр уурлах болов уу? гэж шар шувуу асуулаа. Эрэгтэй удаан гэгч нь бодлогшрон сууснаа: Ямар сонин асуулт вэ? Би том аавыг үүнд уурлахгүй гэж бодож байна, тэр маш дөлгөөн зантай. Гэвч түүний үнэнч нөхөд нь намайг жаахан зовоодог гэхэд: Шар шувуу энэ талаар өөрийгөө битгий зовоо гэж хэлээд нисэн одлоо. Маргааш өглөө нь шар шувуу өмнө нь байсан горхилуу эргэн очтол энэ удаад тэнд урьд өмнө нь ярилцсан эмэгтэй биш харин нэг хүүхэд өвөр дээрээ нэгэн муурыг суулган илж хоёр хөлөөрөө голын усыг цохиж загаснуудыг харан сууж байлаа. Нарны туяа муур, хүүхэд, ус, чулуу, өвс ногоо энэ бүхнийг гэрэлтүүлж байлаа. Шар шувуу зөөлөн гэгч нь модны мөчир дээр суун тэр хүүхэд муурыг яаж илж, муур түүний илэлтэнд баясангаа тэр загаснуудыг мартан эрхлэн хэвтэж байгаа энэ бүгдийг хараад өөрийн эрхгүй баярлан сэтгэл тэнэгэр байв.



Тэгээд шар шувуу ингэж боджээ. Энэ хүүхэд нар яагаад бүх газар тусаж байгаа үүнийг хэн бүтээснийг нэрээр нь мэдэж байгаа болов уу? Эсвэл мэдэхгүй ч байж болох юм гэлээ ч тэр бүгдийг бүтээсэн шидтэний дунд сууж байгаа гэдгээ маш сайн ойлгож мэдэрч байгаа. Энд одоо маргааш нөгөөдөр байхгүй ч тийм чухал биш. Мөн өчигдөр уржигдар бол өнгөрсөн зүйл мөн чухал биш. Шар шувуу энэ бүгд бол нэх сонин биш гэж бодон эргэн тойрноо бүгдийг харж бүгдийг хийж бүтээсэн том шар шувуу, том зэрлэг муур, том загас, том ээж, том аав энэ бүгдийг их нууц гэж нэрлэн шивнэв. Муур нэг нүдээ нээн шар шувууруу нүдээрээ ирмэв. Тэр яагаад мяу гэж дуугарахгүй байна залхуу гэдэг нь гэж тэр бодлоо. Нар жаргахад шар шувуу ойруугаа эргэн нисэх зуураа шар шувуу хулганы нүхийг олж хараад хулганы нүхрүү ингэж орилов. Хү-хү-хү амьд амьтан бүхэн амьтны амиар амьдардаг юм. Та нарын иддэг үр тариа ч гэсэн та нарыг амьдруулах

чадвартай гээд нисэн одлоо.Тэрээр цааш нисэх замдаа сарьсан багваахайтай тааралджээ.



Шар шувуухай чиний нисэж байгаа чинь сайн байна. Хэрвээ чи хэвлийдээ нэгээс илүү хүүхэд тээвэл чиний далавч хүнддээд чи нисэж чадахгүй гэжээ. Сарьсан багваахай хариуд нь чиний зөв гэж хэллээ. Шар шувуу тогосны унтдаг модны дээгүүр нисэн өнгөрөхдөө хөөрхий амьтан гэж бодов. Тэгээд тогос чи яг тахиа шиг хэ, тийм байж нэгээс илүү унтах мод хүсээд байдаг ядарсан амьтан ч бол доо гэж хэлээд цааш нисэх замдаа зэрлэг муурыг олж харлаа. Зэрлэг муур ч түүнийг олж хараад за чи их ухаантай мэдлэгтэй болж чадсан уу? гэж асуухад: бага зэрэг, би бага залуу байна бас сурах зүйл их байна гээд баяртайгаар исгэрчээ. Шар шувуу өө мартаснаас би нэг муурыг хүүхдийн өвөр дээр хэвтээд тэр яаж илүүлж хэвтэж байсныг харсан. Тэр эрхэлж хэвтсэндээ болоод горхиндоо байгаа загасаа харахаа мартчихсан байсан гээч гэхэд зэрлэг муур сонсоогүй юм шиг дүр үзүүлэв. Хэрэв бүх амьтан хүн яг ижил байсан бол уйтгаргүй байх байсан уу? гэж шар шувуухай асуужээ.

Зэрлэг муур дуугай болж шар шувуу цааш нислээ. Эцэст нь шар шувуу өсөж төрсөн модондоо ээж аавыгаа эргэн очиход түүний эцэг эх нь тавтай морил гээд: Чамд бүгдийг хийж бүтээсэн том шар шувуу бүх зүйлийг хэлж өгсөн үү? гэжээ.



Шар шувуу баяртайгаар бүх амьтны юу хэлснийг би бусдад ярина гэхэд ээж нь тэг тэг миний бяцхан хүүхэд минь гэжээ. Гэтэл аав нь: хэрвээ чи энэ бүгдийг хүмүүст ярьвал чамд хэцүү дээ. Яагаад гэвэл хүмүүс үүнд бага итгэдэг юм гэж хэлжээ. Шар шувуу хариуд нь би надад итгэх хүнийг олтлоо ниснэ гээд толгойгоо хөдөлгөв.



ТӨГСӨВ